

ИНЕГ-ЫН УДИРДЛАГУУД БОЛОН ИКАО-ЫН USOAP АУДИТАД
БЭЛТГЭХ ЗОХИЦУУЛАХ ТӨВИЙН ДУНД ХИЙГДСЭН УУЛЗАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2010 оны 1 дүгээр сарын 5

Оролцсон хүмүүс:

Г.Даваа- газрын дарга
Б.Алтанцом –дэд дарга
Ч.Сэрд-Янжив- Ерөнхий менежер бөгөөд НБҮМХ-ийн дарга
С.Манлай- ЗХНХМХ-ийн дарга
Ц.Бат –НААХЗА-ны ДББХ-ийн дарга
М.Эрдэнэбатмөнх- НААХЗА-ны НСҮАХХ-ийн дарга
С.Ерөөлт – НААХЗА-ны ҮГХ-ийн дарга
Ж.Цолмон – НААХЗА-ны ААХХ-ийн дарга
Н.Ганболд - НААХЗА-ны НТЧХ-ийн дарга
П.Мягмарсүрэн – НААХЗА-ны ОХҮТ-ийн дарга
Р.Баатархуяг – НХА-ны дарга
Д.Гантөмөр – Сургалтын төвийн захирал
С.Мөнхбат – Нисэхийн цаг уурын төвийн ерөнхий инженер
А.Азбилэг - ЧХОНБ-ын аюулгүй байдал хамгаалалт хариуцсан дэд захирал
Б.Мөнхжаргал –Аэродромын албаны дарга
П.Батсайхан- НААХЗА-ны ҮГХ-ийн ахлах байцаагч
Н.Энхбат - НААХЗА-ны ААХХ-ийн аэродромын байцаагч
А.Булган - НААХЗА-ны НТЧХ-ийн мэргэжилтэн
Ч.Дарьсүрэн- НААХЗА-ны НСҮАХХ-ийн аюултай ачааны байцаагч
П.Ганбаатар - НААХЗА-ны ААХХ-ийн Холбоо навигацийн байцаагч
Г.Ганхуяг - НААХЗА-ны НТЧХ-ийн а/а-ны хяналтын байцаагч
Ч.Сарансүх - НААХЗА-ны НСҮАХХ-ийн а/а-ны хяналтын байцаагч
Т.Лхагвасүрэн - НААХЗА-ны НТЧХ-ийн ахлах байцаагч
Г.Таванжин – НХҮА-ны технологийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Д.Батхаан – НХҮА-ны ЭХАТЗХ-ийн менежер
Ж.Баярсайхан – АМХ-ийн ахлах мэргэжилтэн
Одгэрэл - АМХ-ийн мэргэжилтэн
Д.Баяртогтох- ТХА-ны Ерөнхий инженер
Н.Батзориг - НБҮМХ-ийн төслийн менежер

ИНЕГ-ын ИКАО-ын аудитад бэлтгэх зохицуулах төв:

- ахлагч -Д.Батчулуун
- гишүүд /П.Пүрэвсүх, Ө.Батсайхан, Н.Батсайхан, Н. Энхтуяа, Д.Хишгээ,

Т.Алтанзул/

Д.Батчулуун: ИКАО-гаас Монгол улсад хийсэн 2001 оны аудитын дутагдлыг хэрхэн хаасан талаарх мэдээллийг дэд зохицуулагч нар Н.Батсайханд гаргаж өгөөрэй, Н.Батсайхан нэгтгэх болно. Мөн СМИС-д протокол асуулгын хариултуудаа оруулаарай. 2010 оны 1 дүгээр сарын 11-ны дотор үйл ажиллагаандаа хамаарал бүхий эрх зүйн бичиг баримтуудыг ирүүлэх тухай бичиг та бүхэнд очсон байгаа. Энэ жагсаалтыг анхааран даруй гарган өгөөрэй. Одоо Солонгос явсан хүмүүс танилцуулгаа хийнэ.

П.Батсайхан: ҮГХ-ийн чиглэлээр туршлага судалсан талаар танилцуулга хийв.

Д.Батчулуун: Тэднийхтэй харьцуулахад манайд байхгүй юм байна уу?

П.Батсайхан: Манайх хэдхэн заавартай байдаг бол тэд чиглэл бүрээр нь задлаад гаргасан олон заавартай юм билээ.

С.Ерөөлт: Бид процесс тус бүрээр заавар болгон задалж байгаа.

Ц.Бат: Урьд нь Шинэ Зеланд уруу туршлага судалсан. Солонгос, Шинэ Зеланд хоёрын хооронд ямар ялгаа байна?

Д.Батчулуун: Шинэ Зеланд, Солонгос хоёрыг харьцуулах аргагүй. Энэ 2 томилолтын чиглэл зорилго өөр байсан. Бид Шинэ Зеланд руу аудитын бэлтгэл ажиллагааг судлахаар явсан. Сая хүмүүсээ Солонгост протоколын асуулгын дагуу хэлтсийн үйл ажиллагаа руу нь түлхүү хандуулж ажиллуулсан. Саяын танилцуулгаас авууштай зүйлс байна. Бид бүх заавраа Монгол хэл дээр болгох нь зөв.

П.Батсайхан: Солонгосчууд бүх материалаа дижитал хэлбэрээр бэлдсэн байна лээ. Аудиторуудыг асуунгуут ард нь бэлэн шууд компьютерээс үзүүлж, танилцуулж байсан гэсэн. Энэ нь тэдэнд илүү давуу талыг өгсөн гэж тайлбарлаж байсан.

Ө.Батсайхан: Тэд дүрэм, заавар ямар зөвлөгөө өгсөн бэ?

П.Батсайхан: 1-рт дүрэм, 2-рт заавар, 3-рт хэрэгжилт байх ёстой гэж зөвлөсөн.

Ч.Сарансүх: Нислэгийн чиглэлээр туршлага судалсан ажлын тайланг тавив. Дараахийг санал болгов. Үүнд:

Тухайн улсад аудит хийгдэхээс 6-н сарын өмнө ИКАО-гаас аудиторууд томилогддог тул наана нь ямар хүн хаанаас ирэх талаар сайн судлах хэрэгтэй гэж байна лээ. Мөн, асуултуудаа Монгол хэл дээр хариулж бэлдэх нь зүйтэй. Заавраас салбарлан журам гаргаж батлуулах шаардлагатай. Бүх чиглэл дээр давхцаж байгаа 4-н асуудал болох албадлага, эрх шилжүүлэлт, техникийн номын сан болон ИКАО-ын стандарт практик зөвлөмжүүдийг нэгтгэж гаргах хэрэгтэй байна. Мөн зөрчлийг нарийвчлан ангилж, хариуцлагыг тодорхой болгох саналтай байна.

Ө.Батсайхан: АОС-г жилд хэдэн удаа ной аа аоаёёò òèéäýã гэж байна?

П.Батсайхан: 1 удаа.

Д.Батчулуун: Хэлтсийн заавруудаа Монгол хэл дээр болгье.

Ганбаатар: Хэлтсүүд Заавраа задлах нэгтгэх, эсэхээ эхлээд тохирох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол зарим нь задлаад, зарим нь задлаагүй Заавартай байж болохгүй.

Д.Батчулуун: Харин тийм учраас үүнийг тодорхой болгох үүднээс бид 10-ны дотор үйл ажиллагаандаа хэрэглэж буй бүх бичиг баримтын жагсаалтыг гаргаж ирүүлнэ үү гэсэн албан бичгийг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Үүний дараа, хаана, ямар бичиг баримт байна, түүнийг хэрхэн цэгцлэх асуудлаа ярья. Сарансүх байцаагчийн тавьсан танилцуулга дээр байгаа нийтлэг асуултуудад èæèè òàðèóèò ° ð ò ä ÷èæýñýí ò¿ñí ýãðèéã та бүхэнд бүх хамаарал бүхий протоколууд (co-related protocols)-ыг базсан жагсаалт ãýæ өгсөн байгаа, эргээд нэг үзээрэй. Багц дүрмийн боловсруулалтыг хурдлах хэрэгтэй байна.

Эрдэнэбатмөнх: Санал авч байна гэж баахан цаг зав үрчихээд эргээд бидний саналыг хүлээж авч тусгахгүй байна.

Д.Батчулуун: Тусгах ёстой зүйлийг тусгах л ёстой. 1 дүгээр сард НТЧ-ээр зөвлөх Nie, 2 сарын эхээр OPS, PEL чиглэлээр зөвлөх Kim (алинаар нь эхэлж авахаа ярих), 3 дугаар сарын 8-14 хооронд аэродромоор зөвлөх Douglas тус тус ирэх байгаа.

Энхбат: Аэродромоор зөвлөх Douglas хэрэггүй. Бид өөр хүн авмаар байна.

Д.Батчулуун: 3 дугаар сарын сүүлчээр дотоод аудит хийлгэе. 3 дугаар сарын 22-26-нд Хонг Конг –оос ANS чиглэлээр зөвлөх ирэх байгаа.

Ж.Цолмон: Их орой байна. Бид наана нь ANS чиглэлээр хүн авмаар байна. Сая Солонгост туршлага судлахад зөвлөх Park ирье гэсэн.

Д.Батчулуун: Танилцуулга хийсэн бүх хүмүүст баярлалаа. Би бус бусад маань шалгуулна гэсэн сэтгэлээр танилцуулгаа бэлдсэн байна. Харин ИКАО-гаас шалгалт хийх аудитуудын нэрс 6-н сарын өмнө гардаг гэдэг худлаа шүү. 2 сарын өмнөөс тодорхой болно гэж НТЧ-ийн зөвлөх Nie хэлж байсан. Ер нь аудитуудыг судлаад наана нь уулзана гэдэг бол худлаа. Бид өөрсдөдөө л найдах хэрэгтэй. Дараагийн уулзалтаар авиакомпаний удирдлагуудтай уулзалт зохион байгуулъя. Хуулийн төсөлд дахин санал авч байгаа. Та бүхэнд хандаж хэлэхэд, 7 хоног бүрийн Мягмар гаригийн энэхүү уулзалтыг тасалдуулахгүй зохион байгуулах үүднээс Мягмар гаригийг дотоод ажил г.м-ээр хувиарлан бусад гадны ажлаас чөлөөлөхийг хүсье.

Ганбаатар: SMS –ээр сургалт явуулж өгөөч гэсэн хүсэлт тавьсан байгаа, энэ асуудал юу болсон бэ? Бидэнд материал, сургалт энэ тэр юу ч байхгүй байна.

Н.Ганболд: COSCAP-NA –ын зөвлөх Kim бол SMS-ийн мэргэшсэн хүн. Яг үнэнийг хэлэхэд Kim монгол ирээд завтай байж байгаад л явдаг ш дээ. Үнэхээр та нар юм хийе гэж бодож байгаа бол SMS-ийн талаар Kim-ийг энд ирэх үеэр нь асуугаад мэдэж авч болно. COSCAP-NA–аас SMS-ийн сургалтыг ИНЕГ-т дөрвөөс таван ч удаа зохион байгуулсан. Бидэнд юу ч байхгүй гэдэг бол худлаа. Аэродромын чиглэлээр SMS-ийн материалыг Чингисболдод бүр 2008 онд тусгайлан өгсөн байгаа.

Н.Батсайхан: МИАТ-ыг 100хувь, Аюулгүй байдлын аудитыг 98 хувьтай шалгуулахад бидний оруулсан хувь нэмэр их байсан. Эрдэнэбатмөнх даргын хэлснээр, аливаа зүйлийг хэн нэгэн рүүгээ чихэх бус харин бие биендээ уян хатан хандъя. Ингэж чадвал 20, 30 хувь нь шууд хаагдана. Бид авиакомпани дээр очоод шалгалт хийхдээ хамгийн түрүүнд тухайн байгууллагын Documentation Control Manual –ыг д эхэлж үздэг. Тэндээс бүх зүйлийг харж болдог, хаанаас юуг нь шалгах вэ гэдгийг тогтоож болдог. Гэтэл бидэнд өөрсдөд маань ийм Заавар байна уу? Байхгүй. Эндээсээ эхлээчээ гэж та бүхнээс уриалж байна. Өөрсдөдөө эхлээд нэвтрүүлъя. Миний хэлэх гэсэн 2 зүйл бол:

1-рт Бие биендээ уян хатан хандъя,

2-рт Чиглэл болгоны Documentation Control Manual –ыг бий болгъё.

Д.Батчулуун: Хоорондоо мэдээлэл солилцоотой ажиллъя. Ажлын уялдааг зохицуулъя. Харин хувь хүмүүс хоорондын асуудал энд хамаагүй шүү гэдгийг хэлье.

Ч.Сэрд-Янжив: Дүрмийн хэлтэс юу хийдэг вэ? Тэнд очоод л гацчих юм. Манай хүмүүс нэлээд олон журам хийгээд явуулсан. Гэтэл, дүрмийн хэлтэс дээр очоод л таг чиг болчих юм, хэдэн сар болж байна. Зарчмын өөрчлөлт хийхгүй бол цааш нь явуулах хэрэгтэй.

Ж.Цолмон: Дүрмүүд ямар хэлбэрээр цааш явж байгаа нь тодорхойгүй байна. Бидний хийсэн дүрэмд яг ямар өөрчлөлт орж өөрчлөгдөөд цааш яам руу явах болсон талаар наана нь бидэнд мэдээлж, хэлж баймаар байна.

Д.Батчулуун: Шинэ Зеландын дүрмийг бид 10-аад жил барьлаа. Зөвлөмжийн цувралаа гүйцэт гаргахгүй байснаар дүрмүүд ойлгомжгүй байна. Эрх зүйн орчныхоо бүрдлийг ойлгохгүй явж байгаад шалгуулах вий дээ.

Мөнхжаргал: Шинэ Зеландад өвөл болдоггүй. FAA-д өвөл болдог. Бид Өвөл болдог газрын заавар дээр үндэслээд 8-н журмыг боловсруулаад Дүрмийн хэлтэст өгсөн. Одоо болтол таг чиг, сар боллоо.

Д.Батчулуун: Газрын дарга баталсан байх хэрэгтэй.

Сарансүх: 2001 онд дүрмээ хийсэн ч нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нь хийгээгүй байна. Дүрмүүд дээр байнга ажиллах мэргэжлийн хүн Дүрмийн хэлтэст хэрэгтэй байна.

Д.Батчулуун: Тиймээ. Бид сүүлийн 8-н жил хийгээгүй ажлын бөөгнөрлийг арилгах гэж энэ 57 саяыг батлуулсан. Бид тухай бүр хийж байсан бол ийм асуудал үүсэхгүй байсан. Энэ асуудлыг шийдвэрлэх гээд НААХЗА-д шинээр ажилд орж байгаа байцаагчдыг эхний хэдэн сар Дүрмийн хэлтэст дүрэм нухуулъя гэдэг саналыг ч тухайн үед гаргаж байсан. Даанч дэмжигдээгүй, ажил хэрэг болоогүй.

Тэмдэглэл хөтөлсөн: Т.Алтанзул